



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 251

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлэн бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын биет бус хөрөнгөд бүртгэлтэй, Баян-Өлгий аймгийн Өлгий суманд байрлах, эзэмших эрхтэй 1,400 м.кв талбай бүхий газрыг 2,321 м.кв болгон нэмэгдүүлж, нийт үнэлгээг 34,815,000.00 (гучин дөрвөн сая найман зуун арван таван мянга) төгрөг (мэргэшсэн үнэлгээчний үнэлсэн дүнгээр) болгож залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Баян-Өлгий аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, дэд хурандаа Н.Баттулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан тайлагнах;

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

